



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЦАГААН-УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 17 өдөр

Дугаар А/158

Цагаан-Уул сум

Г Ажлын хэсэг байгуулах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын нийгэм эдийн засаг, аялал жуулчлалыг хөгжүүлэх, төлөвлөгөө боловсруулах асуулгыг бэлтгэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Дарга: У.Аварзэд (Засаг даргын орлогч)

Гишүүд: П.Чулуунбат (Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч)

М.Дуламжав (Тархвар зүйч)

М.Оюунчимэг (Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл, хоршоо хариуцсан мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: Ч.Эрдэнэчулуун (Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн)

2. Сумын нийгэм эдийн засаг, аялал жуулчлалыг хөгжүүлэх, төлөвлөгөө боловсруулах асуулгыг бэлтгэхдээ олон талын мэдээллийг цуглуулж чанартай хийж гүйцэтгэхийг ажлын хэсгийн ахлагч (У.Аварзэд)-д үүрэг болгосугай.

ДАРГА  С.ГОНЧИГНЯМ

/Zahiramj 2024/